



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/311

Булган сум

Хяналт шалгалт, сургалт зохион байгуулах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.2.12, 17.2.14, 17.2.16, 17.2.17, 17.2.18, 17.2.20, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны “Бугын эвэр түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглох тухай” А/70 дугаар тушаал, Улсын Онцгой комиссын 2023 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгавар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлын 2020 оны “Төлөвлөгөө батлах тухай” 20 дугаар тогтоолын хавсралт “Булган аймгийн 2022-2023 онд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, аймгийн Засаг даргын 2023 оны “Ой, ойн санд аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг түр хориглох тухай” А/194 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын хуурайшилтын үед сумдад гал түймрийн аюулын ангилал аюултай, нэн аюултай зэрэглэлд хүрч ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл нэмэгдэж буй тул орон нутагт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх, бэлэн байдлыг хангуулах хяналт шалгалт, сургалт, мэдээлэл зохион байгуулах ажлын хэсгийг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 5 дугаар сарын 15-ны өдрүүдэд ажиллуулсугай.

2.Засаг даргын нэрэмжит “Гамшгаас хамгаалах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах, хяналт шалгалт, сургалт зохион байгуулах ажил”-ын удирдамжийг 1 дүгээр, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтын тараах материал гарын авлагын зардлыг 2 дугаар, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, сургалт зохион байгуулах ажлын хэсгийн явах зам, хоногийн зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Сургалт, хяналт шалгалтад шаардлагатай зардал 4,993,594 (дөрвөн сая есөн зуун ерэн гурван мянга таван зуун ерэн дөрөв) төгрөгийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтын зардлаас гаргахыг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (П.Булган)-д зөвшөөрсүгэй.

4.Гамшгаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, сургалт зохион байгуулах ажлын хэсгийг ажиллах нөхцөл, удирдлагаар ханган, Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.13, 14.3.14, 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.3, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалтын хэрэгжилтийг ханган, хамтран ажиллахыг Онцгой байдлын газар /хурандаа Ш.Баасандорж/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар (А.Гантөмөр), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/СД
захирамжийн 1 дүгээр хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ
"ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛТГЭЛ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ, ХЯНАЛТ
ШАЛГАЛТ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖИЛ"-ЫН УДИРДАМЖ

Нэг.Зорилго

1.Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, МУ-ын ЗГ-ын 2013 оны "Журам, жагсаалт шинэчлэн болон шинээр батлах тухай" 106 дугаар тогтоол, 2011 оны "Журам батлах тухай (гамшгийн аюулыг зарлан мэдээлэх)" 339 дүгээр тогтоол, "Журам батлах тухай(гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх)" 340 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2023 оны "Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай" 01 дүгээр албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газраас хамтран зохион байгуулах "Стратегийн команд штабын сургууль"-ийн бэлтгэл, гамшгаас хамгаалах бэлэн байдлын Шадар сайд, Онцгой байдлын ерөнхий газрын дарга нарын баталсан удирдамжид хяналт, шалгалтын хэрэгжилт, орон нутгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар, хуулийн этгээд, гамшгаас хамгаалах тусгай болон ерөнхий зориулалтын мэргэжлийн агийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулах урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, сургалтыг зохион байгуулж гамшгийн эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр. Шалгалтын хамрах хүрээ

2.Шалгалтад Булган аймгийн Баян-Агт, Баяннуур, Булган, Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Тэшиг, Сайхан, Сэлэнгэ, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Хялганат тосгоны Захирагч, захирагчийн ажлын алба, төр болон хувийн хуулийн этгээд, аймаг орон нутгийг холбосон төв зам, ой, ойн сан бүхий газар нутгаар хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүд тэдгээрт зорчин яваа зорчигч нар хамрагдана.

Гурав. Шалгалт, сургалт хийх бүрэлдэхүүн, хугацаа

3.Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Ойн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Отгонжаргал, Онцгой байдлын газраас Гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч дэд хурандаа Н.Хишигдорж, гал түймрийн Улсын хяналтын ахлах байцаагч хошууч Х.Чинзориг нараар ахлуулсан тус бүр 4-5 хүний бүрэлдэхүүнтэй 2 ажлын хэсэг 2023 оны 04 дүгээр сарын 20-ноос 05 дугаар сарын 15-ны өдрийн хугацаанд хяналт шалгалт, сургалтын арга хэмжээг зохион байгуулна.

Дөрөв. Ерөнхий зүйл

4.1.Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Ойн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон гал

түймрийн улсын хяналтын дүрэм, Засгийн газрын 2011 оны 339, 340, 2013 оны 106, 2016 оны 339 дүгээр тогтоол, Шадар сайдын баталсан 2023 онд хийгдэх удирдамжид хяналт шалгалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан 2023 онд хийгдэх удирдамжид хяналт шалгалт, Аймгийн ИТХ-ын 2020 оны 20 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны энэхүү захирамж, бусад хууль эрх зүйн баримт бичиг нь уг шалгалтыг зохион байгуулах эрх зүйн үндэс болно.

4.2.Хяналт шалгалтыг зохион байгуулах бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

4.3.Хяналт шалгалтад хамрагдах сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газар, хуулийн этгээд, иргэн нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа баримт, нотолгоог урьдчилан бэлтгэж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хууль ёсны тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

4.4.Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчид нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэн, илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулах, засаж арилгах хугацаатай шаардлага тавьж, гүйцэтгэлийг хангуулах, зөрчил арилаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

4.5.Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг Удирдах албан тушаалтан, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн ажилтан, иргэд, сурагчид гэсэн ангиллаар нэг өдрийн хугацаанд багтаан зохион байгуулах тул сумын удирдлага, хуулийн этгээдийн дарга, захирал, холбогдох мэргэжилтнүүд сургалтын заал, тоног төхөөрөмжийг урьдчилан бэлтгэж, сургалтад хамрагдах хүний нэрс, ирцийн бүртгэлийг бэлтгэсэн байна. Хяналт шалгалт зохион байгуулах ажлын хэсгийн ажил хариуцсан мэргэжилтний заасан хугацаанд сургалтад хамрагдах хүмүүсийг бүрэн байлгах үүргийг тухайн шатны Засаг дарга, дарга удирдлага хүлээнэ.

4.6.Гамшгаас хамгаалах ангиллын сургалтад ажилчдаа бүрэн хамруулаагүй дарга, удирдлага, хамрагдаагүй хуулийн этгээд, иргэн, төрийн албан хаагч, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд зөрчлийн тухай хуулийн дагуу шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

4.7.Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх аргачлалын дагуу сум, байгууллагаас томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүний бэлтгэлийг хангаж, хамтран сумын эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, тайлан гаргах арга хэмжээг зохион байгуулна.

4.8.Засаг даргын нэрэмжит хяналт шалгалт, сургалт зохион байгуулсан илтгэх хуудас, шалгалтын үр дүнгийн мэдээллийг аймгийн Засаг даргад танилцуулж ажиллана.

Тав. Санхүүжилт

5.Аймгийн Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас гаргана.
(тооцоог хавсаргав)

Зургаа. Хяналт шалгалтын үнэлгээ, дүгнэлт


6.1.Орон нутгийн гамшгаас хамгаалах чиглэлээр зохион байгуулж байгаа ажлын үнэлгээг, сумын Засаг даргаас холбогдох хуулиар хүлээсэн эрх үүргийг биелэлтээр тооцон үнэлгээг өгч дүнг сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга, Онцгой комиссын гишүүдэд танилцуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар заавар зөвлөмж, үүрэг өгч, хугацаатай заавал биелүүлэх албан бичиг шаардлага, бичиж биелэлтийг тооцох.

6.2. Хуулийн этгээд, иргэдийн барилга байгууламжид хийсэн шалгалтын явц, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, шалган шийдвэрлэх ажиллагааг байцаагч нар хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд зохион байгуулна.

6.3. Ажлын хэсгийн хийж гүйцэтгэсэн ажлыг, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Онцгой байдлын газрын даргын зөвлөл дүгнэн илтгэх хуудсыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулж цаашид авах арга хэмжээг тодорхойлж хэрэгжүүлнэ.

~АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН АЖЛЫН АЛБА~

Аймгийн Засаг даргын 2023 оны
 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/С/И дугаар
 захирамжийн 2 дугаар хавсралт



Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтын зам
 хоногийн зардлын задаргаа

д/д	Ажиллах сум	Явах км	шатахуун /түлш/				ажиллах хоног	ажиллах хүний тоо	байрны зардал	бүгд
			тоо хэмжээ /литр/	нэгжийн үнэ	бүгд үнэ/төг/	томиллолт				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Нэгдүгээр чиглэл										
1	Булган									
2	Сайхан	101	16.16	3760	60761.6	24000	1	4	20000	176000
3	Баян-агт	72	11.52	3760	43315.2	24000	1	4	20000	176000
4	Уньт	100	16	3760	60160	24000	1	4	20000	176000
5	Хутаг-Өндөр	50	8	3760	30080	24000	1	4	20000	176000
6	Тэшиг	103	16.48	3760	61964.8	24000	1	4	20000	176000
7	Булган	250	40	3760	150400	0				0
8	Бугат	55	8.8	3760	33088	24000	1	4	20000	176000
9	Сэлэнгэ	100	16	3760	60160	24000	1	4	20000	176000
10	Хялганат	30	4.8	3760	18048	24000	1	4	20000	176000
11	Хангал	25	4	3760	15040	24000	1	4	20000	176000
12	Булган	100	16	3760	60160	0	0	0		0
	Дүн	986	157.76		593178		9			1584000
Хоёрдугаар чиглэл										
1	Булган									
2	Орхон	22	3.52	3760	13235.2	24000	1	4	20000	176000
3	Хишиг-Өндөр	46	7.36	3760	27673.6	24000	1	4	20000	176000
4	Бүрэгхангай	50	8	3760	30080	24000	1	4	20000	176000
5	Дашинчилэн	70	11.2	3760	42112	24000	1	4	20000	176000
6	Баяннуур	70	11.2	3760	42112	24000	1	4	20000	176000
7	Рашаант	80	12.8	3760	48128	24000	1	4	20000	96000
8	Гурванбулаг	75	12	3760	45120	24000	1	4	20000	176000
9	Могод	75	12	3760	45120	24000	1	4	20000	176000
10	Булган	135	21.6	3760	81216	0	0	0		0
	Дүн	623	99.68		374797		8			1328000
	Нийт дүн	1609	241.44		967974		17			2912000
Нийт дүн										
	Томиллолт, байрны зардал									2912000
	Шатахуун									967974
	Дүн									3879974

Тайлбар: Land cruiser long-76, Land cruiser long-78 маркийн автомашинаар явна.
 100 км-т 16

ОХ дүгээр сарын 25-ны өдрийн 1/5М дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтын тараах материалын зардлын задаргаа

Д/д	Сумын нэр	сургалтанд оролцох	Ой, хээрт зорчигчдод түймрээс сэргийлсэн санамж материал			Ой, хээрийн түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх материал			Нийт үнэ/төг/
			тоо хэмжээ/ш/	нэг бүрийн үнэ /төг/	нийт үнэ	тоо хэмжээ/ш/	нэг бүрийн үнэ /төг/	нийт үнэ	
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Баян-агт	50	1	25000	25000	25	1500	37500	62500
2	Баяннуур	45			0	15	1500	22500	22500
3	Бугат	60	2	25000	50000	25	1500	37500	87500
4	Булган	60			0	25	1500	37500	37500
5	Бүрэгхангай	45	1	25000	25000	20	1500	30000	55000
6	Гурванбулаг	60			0	15	1500	22500	22500
7	Дашинчилэн	60			0	15	1500	22500	22500
8	Могод	50	1	25000	25000	20	1500	30000	55000
9	Орхон	60	2	25000	50000	30	1500	45000	95000
10	Сайхан	60	1	25000	25000	20	1500	30000	55000
11	Сэлэнгэ	110	2	25000	50000	35	1500	52500	102500
12	Хангал	90	1	25000	25000	30	1500	45000	70000
13	Хялганат	40			0	20	1500	30000	30000
14	Хутаг-Өндөр	100	2	25000	50000	35	1500	52500	102500
15	Уньт	40	1	25000	25000	20	1500	30000	55000
16	Хишиг-Өндөр	50	1	25000	25000	20	1500	30000	55000
17	Тэшиг	70	2	25000	50000	35	1500	52500	102500
18	Рашаант	50			0	15	1500	22500	22500
19	БОАЖГазар				0	21	1500	31500	31500
20	ОБГазар				0	22	1500	33000	33000
	Дүн	1100	17		425000	463		694500	1119500